

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-22

1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны
өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 4-21

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр
тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудал 21-22

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
08 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Мөнхбаатар, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын дэд дарга Д.Цолмон, Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх,

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Анар, Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохиxсүрэн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайдын зөвлөх Л.Эрдэнэбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны сайдын зөвлөх Ц.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	6
Бүгд:	20

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудалтай танилцлаа.

Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
13 цаг 25 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Гарахгүй байгаа юм уу, тийм үү? Ямар ч л байсан 60 хувийн ирэх ёстой гишүүдийн 60 хувь нь ирсэн байна. Ирц бүрдсэн байна. Ингээд ирц бүрдсэн тул хуралдааныг эхлүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул ТББХ-ны 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааныг ийнхүү эхлүүлье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 2 асуудал байна. 1.Монгол Улсын ЗГ-ын 2024 оноос 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн. 2.Монгол Улсын ҮХЦ-ийн 2024 оны 01 дүгээр тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудал. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё доо. Ажлын хэсэг, ажлын хэсгээ оруулъя.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлгийг явуулъя. Яасан гэнэ вэ? Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т нэгдсэн хуралдааны хуралдаан хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Улсын Их Хурлын дарга тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын нийт гишүүд яаралтай хүргүүлж, энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцүүлнэ гэж заасан байгаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг, анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг гэсэн 3 үе шаттайгаар хэлэлцэж батална гэж заасан байгаа. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2-т ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох Байнгын хороогоор хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийнэ гэж заасан байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Лувсаньямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд байгаа юу? Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Эрдэнэбилэгийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн 20 минутын хот үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Салдангийн Одонтуяа Байгаль

орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууц, орон сууцжуулалтын сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, эрдэс баялгийн сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд.

Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Бямбажавын Ганбат ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны ТНБД, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, Лхагваванажавын Мөнхтүшиг ГХЯ-ны ТНБД, Сандагдоржийн Батболд ЗТЯ-ны ТНБД, Чимэдицэрэнгийн Цэвэгдорж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД, Сандагийн Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Төмөрхуягийн Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны ТНБД, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны ТНБД.

Пүрэвийн Зохихсүрэн Ерөнхий сайдын зөвлөх, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваасүрэнгийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга, Лувсанцэрэнгийн, Лувсандоржийн Эрдэнэбат Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын зөвлөх, Цэрэнпилийн Мөнхбат Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны сайдын зөвлөх гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Төсөл санаачлагчдын илтгэлийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр танилцуулна. Гантөмөр сайдыг урьж байна.

Л.Гантөмөр: Баярлалаа. 3 минутад амжихгүй байж магадгүй, хугацааг нь бас ахиу тавьчхаарай. Эрхэм хүндэт Их хурлын гишүүд, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дугаар хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж байна. Хамтарсан ЗГ хөгжлийн тулгамдсан асуудал,

тулгарч буй зорилтуудыг илүү хурдан, үр дүнтэйгээр шийдвэрлэх бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр тогтвортой хамтран ажиллах зорилгоор бид нар Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Шинэ Зеланд, Австрали зэрэг олон ардчилсан парламентын засаглалтай улсуудын туршилагыг судалж, Хурдтай хөгжлийн төлөөх зориг хамтарсан ЗГ-ын гэрээг байгууллаа.

Дээрх гэрээгээ удирдлага болгож, 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн МАН, АН, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулаад өргөн барьж байна. Энэ удаагийн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг тодорхой хэмжигдэхүйц, хэрэгжихүйц ач холбогдолтой, эрэмбэ дараатай, цаг хугацаатай байх зарчимд тулгуурлаж, хүний хөгжлийн түвшнийг илэрхийлэгч хүний хөгжлийг дэмжих, хүний хөгжлийн индекс, эдийн засгийн эрх чөлөөг дэмжиж буй эсэхийг дүгнэдэг, эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс, боловсролд зарцуулж буй хөрөнгө, шинжлэх ухаан, технологийн судалгааны нийтлэлүүд, оюуны өмч бүртгүүлэх хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг илэрхийлдэг Дэлхийн инновацын индекс, улсын төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа эсэх, төрийн нийт албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа эсэх, төр засаг нь авлигын эсрэг үр дүнтэй тэмцэж байгааг илэрхийлдэг Авлигын төсөөллийн индекс зэрэг олон улсын хөгжлийн индексүүдийг тооцож, илүү бодитойгоор хэрэгжихүйц зорилго зорилтуудыг боловсрууллаа.

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд Улаанбаатар хот 20 минутын хот, бие даасан эдийн засаг бүхий дагуул хот, бүсийн төрөлжсөн хөгжил, орон нутгийн

хөгжил, чинээлэг Монгол хүн, эрдэм боловсролтой Монгол хүн, эрүүл Монгол хүн, баялагтаа эзэн Монгол хүн, эдийн засгийн эрх чөлөө, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн төрөлжилт, либералчлал, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт, хүний эрх, эрх чөлөө, авлигагүй засаглал, цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл, үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар ба амар тайван нийгэм зэрэг 16 зорилго, 62 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 569 үйл ажиллагааг тусгалаа.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн Их, Бага тойруу буюу 770 га газарт төвлөрсөн төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх буюу *go mongolia* ган татлагат гүүрний төсөл, Хөшигийн хөндийн туннелийн төслийг хэрэгжүүлнэ. Зуунмод хотын Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна. Хүнд ээлтэй эмнэлэг, сургууль, цэцэрлэг, эрүүл аюулгүй ногоон байгууламж, үзвэр үйлчилгээ, соёл, спортын үйлчилгээг 20 минутын дотор авах хүний төлөө шинэ стандарт бүхий амьд хот төлөвлөлтийг цогцоор нь дахин хийж, Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040-ийг боловсруулж батлуулна.

Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвийн орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20 мянган айлын орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шар хад, Дэнжийн мянга, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулах юм. Ипотекийн зээлийн санхүүжилтийн 50-аас багагүй хувийг дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно. Олон улсын чанартай 88км шинэ тойрог зам Туулын хурдны замыг барьж, ачаа тээврийн

хөдөлгөөнийг хотын гадуур хурдан шуурхай нэвтрүүлэх ажлыг хийнэ.

Бид хамтдаа улс орноо бүсчлэн хөгжүүлж, Хархорин, Шинэ Зуунмод зэрэг шинэ хотууд, аймгийн төвүүдийг хооронд нь болон хилийн боомтуудтай холбох 5 тойрог дэд бүтцийн мега төслийн их бүтээн байгуулалтыг яаралтай хэрэгжүүлж дуусгана. Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж, бүс бүхэнд ялгаатай татварын бодлогыг хэрэгжүүлэх, бүсийн онцлогт таарсан хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байгаа юм. Иймд хангайн бүсийг уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн хот байгуулалтын дэд бүс, баруун бүсийг эрчим хүчний төрөлжсөн байгалийн аялал жуулчлалын дэд бүс, хойд бүсийг байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс, говийн бүсийг аж үйлдвэрийн төрөлжсөн ногоон эрчим хүчний дэд бүс, төвийн бүсийг хөдөө аж ахуйн төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс, зүүн бүсийг түүхэн, аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс болгон төрөлжүүлэн хөгжүүлэх юм.

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд үндэсний баялгийн сангийн тогтолцоог улам бэхжүүлж, үндэсний баялгийн сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, эрчим хүчтэй, эрчим хүчтэй, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцад олгох дэмжлэгийг нэмэгдүүлж, хашаандаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлж, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, Имонгол платформоор дамжуулан иргэн бүрд хуримтлалын данс нээнэ.

Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох Боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлэх юм. Шинжлэх ухаанч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар, асуудалд суурилсан шүүмжлэн эргэцүүлэх чадамжтай, эрүүл чийрэг,

эрдэм боловсролтой, хариуцлагатай гэр бүлийн гишүүн байх дэлхийн Монгол иргэнийг бэлтгэх боловсролын тогтолцоог бэхжүүлнэ.

Хөдөлмөрийн зах зээлийн эргэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх үйл хэрэгт шилжинэ. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж буй хүчин зүйлс архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжих боловсролыг олгох юм. Олон улсын зохистой дадал стандартыг бүрэн нэвтрүүлэхийн зэрэгцээ эм, эмнэлгийн хэрэгслийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эмийн импортыг бүрэн цахимжуулна. Монгол хүн чанартай эм хэрэглэдэг тэр цаг үе рүү шилжинэ гэж зорьж байна. Иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи, телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.

2025 оныг залуучуудын жил болгон зарлаж, оюутан залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулж, нийгмийн идэвх, оролцоо, хөгжлийг дэмжинэ. Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна. Та 2 жоохон ярихаа болих уу, давхар сонсогдоод байх юм.

Эдийн засгийн бодлогын хүрээнд хувийн хэвшлийн бизнесийн орчныг бүрдүүлж, татварын реформ хийж, төрийн, төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх тэр зарчмыг баримталж, бизнесийн багц хуулиудыг баталж, зах зээл дэх төрийн

зохицуулалтыг багасгаж, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлнэ. Хөрөнгө оруулалт, Худалдаа, Дампуурлын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа багц хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөж, төрийн худалдан авах ажиллагааг хиймэл оюун ухааныг ашиглан зохион байгуулна. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, тэтгэврийн нөөц сан, хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын менежментээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ. Гадаадын банк, салбар нэгжийг гадаадын банкны салбар нэгжийг дотоодын зах зээлд нэвтрүүлж, гадаадын хөрөнгө оруулалттай банк санхүүгийн байгууллага Монголд үйл ажиллагаагаа явуулна.

30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын реформыг цаг алдалгүй эхлүүлж, эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аж үйлдвэржилт, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх мега төслүүдийг хэрэгжүүлнэ. Төслүүдийг амжилттай хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 5-аас 6 ба түүнээс дээш хувьд, инфляцыг 1 оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ. Түүнчлэн эдийн засгийн эрх чөлөөний байдлын үзүүлэлт дэлхийн инновацын үзүүлэлтийг тус тус 10 байраар ахиулах зорилтыг дэвшүүлж байна.

1 хүнд ноогдох ДНБ-ийг 8-аас 10 мянган ам.доллар-т хүргэхийг зорьж ажиллана. Хүний хөгжлийн үзүүлэлтийг өнөөдрийнхөөс 10 байраар ахиулж, ядуурлын түвшнийг 2 дахин бууруулна.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээг авна. Өнөөдөр Улсын Их Хурлын дарга хэлсэн үгэндээ хуулиас давсан журам байхгүй. Хууль хэлэлцүүлэх үед дагасан журмыг давхар баталдаг байх гэдэг энэ зарчмыг бид цаашидаа хууль өргөн барихдаа хэрэгжүүлж ажиллана.

Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллана. Шүүхийн процессыг цахимжуулж хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцыг ил тод болгож, хэрэг маргааныг түргэн шуурхай үр дүнтэй шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, иргэдийн шүүх засаглалд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ. Цахим засаглалын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн үйл ажиллагааны ил тод байдал хүртээмжийг нэмэгдүүлнэ. Хүний оролцоогүй хиймэл оюун ухаанд суурилсан төрийн үйлчилгээний ухаалаг ИМонголиа нэгдсэн системийг хөгжүүлж, бүртгэл нэртэй зөвшөөрлүүдийг цуцалж, зөвшөөрлийг онлайн-аар өгдөг системийг нэвтрүүлж бүрэн цахимжуулах юм.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийг улс төрийн хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрэлдүүлж, уул уурхайн төрийн өмчит компаниудыг олон улсын менежментийн багаар удирдуулж, үр ашгийг нь дээшлүүлнэ. Ер нь бид ТӨК-удыг болбол ашигтай байх гэдэг үндсэн зарчим дээр суурилж үйл ажиллагааг нь удирдаж явуулах юм.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын зөвлөх үйлчилгээ авч, цомхон чадварлаг төрийн албыг бий болгох реформыг хэрэгжүүлж эхэлнэ. Төрийн албаны хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний цогц системийг хөгжүүлж, гүйцэтгэлийн үнэлгээнд бүрэн гүйцэд ишилжих юм. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог улам бүүр сайжруулна. Дээрх засаглалын бодлогыг хэрэгжүүлснээр засаглалын үзүүлэлтийн индекс болон дэлхийн сайн орны үзүүлэлтийг тус бүр 10 байраар, авлигын индексийг 30 байраар тус тус урагшлуулна.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан бодлого, зорилтын хүрээнд бүтээн байгуулалтын үндэсний хэмжээний томоохон 149 төслийг хэрэгжүүлэхээр бид төлөвлөж байна. Эдгээр төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвилийн чадавх, манлайлал нэн тэргүүнд тавигдах бөгөөд нийт төслийн 54,1 хувь нь дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд, 18 хувь нь аж үйлдвэрийг хөгжүүлэхэд, 27,8 хувь нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд тус тус чиглэгдэж байгаа юм.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд эдийн засгийн өсөлтийг жил бүр 5 хувиас доошгүй түвшинд хадгалах бодлогыг баримтлах шаардлагатай бөгөөд нийт 120 орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шаардлагатай байгааг санхүүгийн урьдчилсан тооцоо гарсан байна. Эдгээрээс улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12,3 хувийг санхүүжүүлэх боломжтой бөгөөд төр хувийн хэвилийн түншлэлээр 24,4 хувь, гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгөөр 17,3 хувийг тус тус хэрэгжүүлж, үлдсэн 46 хувийг бусад

эх үүсвэрийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

Төр хувийн хэвилийн түншлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, төсөв мөнгөний бодлогын уялдааг сайжруулахад чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ чиглэлийн шинэчлэлийг тодорхой түвшинд гаргах юм. Дэлхий дахиныг хамарсан геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, байгаль цаг уур, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн давагдашгүй хүчин зүйлс зэрэг гадаад дотоодын хүчин зүйлсийн нөлөөнөөс үүдэн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд учирч болзошгүй эрсдэлийг тооцон үзэж, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв мөнгөний бодлогын уялдааг хангаж эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Төсөл санаачлагчаас үзэл баримтлалтай холбоотой асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Нэрсээ кнопоороо. Цогтгэрэл, болсон уу? Цогтгэрэлээр тасалъя, Бямбацогт гишүүнээр тасалъя. Шижир гишүүний микрофоныг нээе.

Ө.Шижир: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. ЗГ-ын мөрийн хөтөлбөр гээд бид нар 1990 оноос хойш Монгол Улсад Улсын Их Хурал байгуулагдаж, ЗГ гэж бүтэц бий болсноос хойш үндсэндээ 800 орчим бодлогын баримт бичиг

үйлдвэрлэсэн юм байна лээ. Энгийнээр хэлэх юм бол боодол, боодол цаас гэсэн үг. Тэгээд өнөөдөр энэ хийсэн байгаа 800 орчим бодлогын баримт бичиг өнгөрсөн хугацаанд хийсэн, хүчингүй болсон, 290 шахуу, хугацаа нь дууссан бас 100 шахуу, огт хэрэгжээгүй гээд энэ бодлогын баримт бичгүүд дээр энэ олон яамны газар, хэлтсийн дарга нар маань үнэлэлт дүгнэлт хийгээд, тухайн бодлогын баримт бичгүүд маань хэрэгжилт дээр дүгнэлт хийсэн юм байдаг юм уу, байдаггүй юм болов уу? Энийг сайн мэдэхгүй байна. Өнөөдрийг хүртэл яг энэ ийм олон зузаан цааснууд дээр яг бодитоор гарсан дүгнэлтийг олж уншсангүй.

Тэгээд мөн мөрийн хөтөлбөр гээд хэрэгжүүлээд, энэ ... тухай, бүсчилсэн байгаа байдлуудыг нь харахад жишээ нь баруун бүс эрчим хүчний тэргүүлэх чиглэлтэй гэсэн мөртөө яг эрчим хүч тал дээрээ суулгасан 2 төсөл харагдаж байна. Яг энэ өгсөнд, тараасан төсөл дээрээ. Тэгэхээр энэ маань өөрөө яг эрчим хүчний хараат байгаа байдлыг маань бүрэн хангаж чадах уу, чадахгүй юу гэдэг дээр нэг тодорхой хариулт авмаар байна. Яагаад гэхээр баруун бүс маань одоо ОХУ-аас авч байгаа нийт эрчим хүчний бараг 10 орчим хувийг, улс маань өөрөө нийтдээ 50 орчим сая доллар зөвхөн эрчим хүчний худалдан авах дээр зарцуулж байна. Тэгтэл энд байгаа 2 төсөл маань өөрөө хэрэгжээд бодитой байдлаар энэ 50 орчим сая доллароо хэрэгжүүлэхэд хангах уу, хангахуйц уу гэдгийг бас бодитой хариулт авмаар байна.

Өнөөдрийн байдлаар ДНБ 5 мянган доллар, 4 жилийн дараа 10 мянган доллар хүргэнэ гэсэн. Өчигдөр Эдийн засгийн хөгжлийн яамнаас асуултад хариулахдаа жилд 14 хувийн өсөлттэйгөөр байж бид нар 10 мянган долларт хүргэнэ гэж хариулж байна лээ. 4 жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт нь 14 хувиас дээш өссөн улс дэлхий дээр ер нь байна уу? Бид нар 4 жил дараалж 14 хувийн өсөлт хийж байж 10 мянган

долларт хүрнэ шүү дээ. Тэгэхээр яг энэ бодитой тооцооллоо бид нар яаж хийсэн юм бэ гэдгийг хармаар байгаа юм.

2 дугаарт бол шинэ Зуунмод гээд нэг хотын тухай энэ тараасан өргөн мэдүүлсэн төсөл дээр танилцуулга нь алга. Тэгээд интернэтээс google-дээж байгаад 31 мянган га дээр Шинэ Зуунмод хот гэдэг газрыг байгуулах юм байна. Энэ төслөө бас нэг тараачхаач. Тэгвэл бас нэг ойлголт авмаар байна. Тэгээд 31 мянган га-гийн маань өнөөдөр яг хэдэн хувь нь улсын хэрэгцээнд авчихсан байгаа юм, хэдэн хувь нь хувийн хэрэгцээнд байгаа юм бэ энэ тал дээр бас тодорхой хариулт өгөөч. 31 мянган га чинь их том шүү дээ. Тэгээд 150 мянган хүн амьдарна тийм суурьшлын бүс хийнэ гэхихсэн байна. Гэтэл тэрний дэд бүтцийн ажлууд нь эхэлсэн юм уу? БХБЯ-ны 2022 оны тайлан дээр Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээ гээд биччихсэн байна лээ. Тэгээд тэр бүтээн байгуулалт маань юу болж байгаа юм бэ? Тэгээд газартай холбоотой 31 мянган га чинь хэд нь хувийн хэвшилд оччихсон юм бэ, хэд нь төрд байгаа юм бэ? Түүн дээр тодорхой хариултауд авмаар байх юм.

Ж.Бат-Эрдэнэ: Шигжир гишүүний асуусан асуултад эхлээд Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Гантөмөр сайд хариулах уу. Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Мэдээж Монгол Улсын ЗГ болоод Их Хурал дээр батлагдсан, дээр нь Ерөнхийлөгчийн энэ зүгээс Аюулгүйн зөвлөл дээр батлагдсан бичиг баримт гэх юм болбол зөндөө байгаа. Ер нь ийм бичиг баримтаа баталж, бодлогынхоо судалгааг хийж, бодлогын төлөвлөлт хийх нь болбол Монгол төрийн үүрэг. Өнөөдөр хүртэл болбол энэ төлөвлөлт нь өөрөө амьдрал болоод зах зээл, тэгээд тухайн цаг үеийнхээ нөхцөл байдалтай холбогдож чадаагүй, магадгүй төлөвлөсөн зүйлийнхээ ард гарахад садаа болдог, нэг

нь эсэргүүцэж зогсоодог ийм үзэгдэл болбол хавтгайрсан газар авсан.

Тийм учраас болбол тодорхой зорьсон зорилгууд, төлөвлөлтүүд бол хэрэгждэггүй гэдэг дээр болбол би Шижир гишүүнтэй бол санал нэг байна. Яг хэд нь хэрэгжээд, хэд нь хэрэгжээгүй вэ гэдэг дээр болбол аудит дээр бол ерөнхий хандлагын дүгнэлтүүд бол байгаа. Энийг цаашаагаа илүү нарийвчилсан судалгаанууд хийдэг байх гэдэгт бол би эргэлзэхгүй байна. Хэрэг эрхлэх газар болбол энэ дээр тодорхой тоо баримтуудыг яриад явах ёстой.

Бүсийн хөгжлийн асуудал болбол ингээд 4 том зорилтын нэг болж орж ирж байгаа юм. Ер нь Монгол Улс болбол бүсчилсэн байдлаар хөгжсө, тэгэхгүй болбол энэ тархай бутархай байдал, газар нутгийн энэ орон зайн энэ хуваарилалт болбол ерөөсөө болохгүй байна гэдэг зүйлийг олон жил ярьсан. Тэгээд бид бол 76 парламенттай парламентын засаглалын 30 жилд 34 жилийн амьдралд цэг тавиад, одоо 126 гишүүнтэй яг бүс нутгийг төлөөлөөд гарч ирж байгаа бүс нутгийн хөгжлийн бодлогыг боловсруулаад явж байгаа ийм Их Хурлын гишүүдээс бүрдсэн ийм парламент анхныхаа чуулганыг эхлүүлж байгаа юм. Тийм учраас болбол бид нар анх удаагаа бүүр нэг тийм жалга довын үзлээс салсан, хөрөнгийн бодлогыг анх удаагаа бид боловсруулах шаардлагатай болж байгаа юм.

Энэ утгаараа бүсчилсэн хөгжлийн бодлогыг онцгойлон анхаарч байгаа юм. Бүсчилсэн хөгжил дотор мэдээж Улаанбаатар хотын асуудал орж байгаа. Тийм учраас энэ Улаанбаатар хотын тэлэх бодлоготой уялдуулаад Шинэ Зуун мод төслийг өнгөрсөн жилээс эхлээд хэрэгжүүлсэн юм билээ. Ер нь тэр Хөшигийн хөндийн нисэх буудал ашиглалтад орсноос хойш тэр Хөшигийн хөндийн хэсгийг яаж хөгжүүлэх вэ гэдэг зүйл бол их олон жил яригдсан, тодорхой дэд бүтцийн ажлууд хийгдсэн. Хэрвээ энд манай Шинэ

Зуунмодын захирагч байгаа болбол өнөөдөр аль хэсэг нь хамгаалалтад юу ЗГ-ын мэдэлд байгаа, аль хэсэг нь хувийн хэвшилд байгаа гээд нарийн мэдээллүүд манай дээр манайханд байгаа байх. Тэр тухай мэдээллээ өгөөд яваарай.

Ер нь бид 10 мянган ам.долларыг эдийн засгаа 10 мянган ам.доллар-т хүргэе 1 хүнийхийг гэдэг зорилгыг болбол маш зоригтойгоор дэвшүүлж байгаа юм. Энэ рүүгээ явна. 14 хувийн өсөлт гэдэг нь болбол одоо байгаа тодорхой өсөлт чинь инфляц нь хасагдаад бага хувьтай харагддаг байхгүй юу даа. Яг өнөөгийн үнэ цэнээрээ яг өнөөдөр байгаа ДНБ-ий хэмжээг үйлдвэрлэл эрхэлж байгаа, худалдаа эрхэлж.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Цагтаа товчхон шиг ярихгүй болбол багтахгүй байна шүү, тодорхойнхон шиг. Тавинбэх дарга ЭХЯ-ны ТНБД. Тавинбэх хэдэн номер вэ? Наадах чинь хэдэн номер юм, хэдэн номер юм бэ? 6 номерын микрофон дээр суучих даа. 6 номерын, 6 юм уу, хэд юм бэ наадах чинь? 6 юу, 6 номерын микрофоныг нээе.

Н.Тавинбэх: Асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар баруун бүс ОХУ-аас нийт хэрэглэдэг эрчим хүчнийхээ 70 орчим хувийг импортоор авч хангаж байгаа. Импортоор эрчим хүч авч байгаа баруун бүсийн хэрэглээний бүтцэд ахуйн хэрэглээ дийлэнх болж зонхилдогтой холбоотойгоор хамгийн их алдагдалтай ажиллаж байгаа эрчим хүчний систем байгаа. Бид өнгөрсөн ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн бүрэн эрхийн хугацаанд баруун бүсэд Ховдын Мянгад, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Завхан аймгийн төвд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд болоод 30мвт-ын батарейн цэнэгт хураагуурыг ашиглалтад оруулсан байгаа. Одоо энэ баруун бүсийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн бүс нутаг болгохтой холбогдуулж ЗГ-ын хөтөлбөрт Эгийн голын, Эрдэнэбүрэний усан цахилгаан станц, суурь хэрэглээ хангах зорилгоор Тосонцэнгэлд 30мвт-ын нүүрсний цахилгаан станцыг барьж байна.

Өмнө нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк Цаг уурын өөрчлөлтийн сантай хамтарч хэрэгжүүлж байсан түрүүний 3 аймгийн төв дээр барьсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн төслүүд бас үргэлжлэх ёстой. Энэ Есөнбулаг дээр бас 15мвт-ын нар эсвэл салхины эх үүсвэрийг барьж ашиглалтад оруулна гэж байгаа. Энэ төлөвлөсөн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаж хэрэгжсэн, хэрэгжих гэж байгаа төсөл хөтөлбөрүүд хэрэгжихвэл, бүрэн хэрэгжихвэл баруун бүсийг дотоодын эх үүсвэрээс дийлэнхийгээ ногоон цэвэр эх үүсвэрээс хангах ийм боломжтой болно.

Дээр нь бид нар бас Эрдэнэбүрэний УЦС ашиглалтад орж байгаатай холбоотойгоор баруун бүсийг төвийн эрчим хүчний нэгдсэн системтэй холбож байгаа. Энэ болбол бас баруун бүсийг дотоодын эх үүсвэрээс хангах бас нэг суурь дэд бүтэц болох учиртай.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ эрчим хүчний дутагдлаас ингээд гарах юм уу гэсэн асуулт байсан юм биш үү? Тийм. Наадуулыгаа хийснээрээ эрчим хүчний энэ дутагдлаасаа бид нар гарч чадах юм уу? Ямар төлөвлөгөө ямар юутай орж ирж байгаа юм бэ, төлөвлөлттэй орж ирж байгаа юм бэ гэж байна шүү дээ.

Н.Тавинбэх: Би маш тодорхой хэллээ шүү дээ. Дотоодын эх үүсвэрүүдээс баруун бүсийн эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах, түүн дотроо дийлэнхийг нь цэвэр ногоон эрчим хүчний дотоодын эх үүсвэрээс хангах боломжтой болно. Импортоор болбол бид дотоодын эх үүсвэрээс хэрэгцээгээ хангаснаар импортоос тасална гэсэн үг биш. Импортыг болбол аюулгүйн нөөцийн зориулалтаар ОХУ-тай дэд бүтцээр холбоотой хэвээрээ байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хэвээрээ байна гэсэн үү?

Н.Тавинбэх: Аюулгүйн нөөцийн үүднээс олон улсад байдаг жишгийн дагуу. Хэрэгцээгээ болбол дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах боломжтой болно.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын хэмжээнд тийм үү?

Н.Тавинбэх: Баруун бүсийн хэмжээнд.

Ж.Бат-Эрдэнэ: Баруун бүсийн хэмжээнд, улсын хэмжээнд асуугаад байна шүү дээ зөв үү Шижирээ?

Н.Тавинбэх: Баруун бүс гэж асуусан.

Ж.Бат-Эрдэнэ: Баруун бүс үү. Сая 1 юу асуулт байсан шүү дээ. Тэр юутай газар Шинэ Зуунмодтой холбоотой Барилга, хот байгуулалтын ТНБД хэн билээ, яг хэдэн га газар хадгалаатай байгаа вэ гэдэг талаар тодруулсан шүү дээ. Ямар төлөлттэй байгаа вэ? Хот байгуулалтын төрийн нарийн алга уу? Төмөрхүү. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 3 зүйл асууя. Нэгд ирэх 4 жил хамтарсан ЗГ татвартай холбоотой ямар шинэчлэл хийх гэж байна вэ? Татвар өндөр байна, бага орлоготой, жижиг дунд бизнес эрхэлж байгаа улсуудад ачаалал их байна гээд л их ярьдаг. Татварын хувь хэмжээг бууруулах, хөнгөлөлт урамшуулал өгөх гэдэг юм уу энэ чиглэлээр хэрхэн яаж ер нь ирэх 4 жил татвар нэмэгдэх юм уу, нэмэгдэхгүй юм уу, буурах юм уу, буурахгүй юм уу энэ дээр яг тодорхой хариулт өгөөч. Буурна гэвэл ямар чиглэлийн татварыг бууруулахаар ярилцаж байгаа юм. Нэмэгдүүлнэ гэвэл ямар чиглэлийн татварыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа юм бэ? ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт.

Энэ бол хүн болгон иргэн болгон, ААН-тэй холбоотой асуудал. Манай улс дэлхий дээр олон улсын жишигээр татварын тогтолцоо хувь хэмжээ ямар түвшинд байгаа юм бэ? Татварын бааз суурийг яаж өргөжүүлэх гэж байгаа юм бэ гэдэг энэ дээр нэгд асуулт байна.

2-т банкны реформ. Өнөөдөр Монгол Улсын иргэн болгон айл өрх болгон ямар нэг зээлтэй байгаа. Банкны зээлийн хүүгээс хүүгийн хооронд үндсэндээ дарлуулж байгаа юм. Энэ зээлийн хүүг бууруулах чиглэлээр ирэх 4 жилийн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт хэрхэн яаж тусаж байгаа юм бэ? Энэ гадаадын санхүүгийн эх үүсвэр санхүүгийн чадавхтай энэ банкны салбарыг оруулж ирж болохгүй юм уу? Олон жил ярилаа. Магадгүй энийг оруулж ирэх сонирхолгүй бүлэг хэсэг нөхдүүд байдаг юм шиг байгаа юм. Энэ хэдэн томоохон гэж хэлэх банкнууд үндсэндээ ингээд лоббидоод. Тэгээд санхүүгийн чадавхтай өрсөлдөөнийг бий болгох, энэ салбарт өрсөлдөөнийг бий болгох, хүүг бууруулах энэ бололцоо боломжийг энэ ЗГ ирэх 4 жил яаж эрэлхийлж ажиллах юм бэ? Үгүй ээ ингэж ажиллаж чадвал үгүй ээ мөн олон хүнд буян болохоор байна. Олон айл өрхөд буян болохоор байна. Ийм л хүлээлттэй байгаа энэ ЗГ-аас. Ийм томоохон хэмжээний хүлээлтийг энэ хамтарсан ЗГ бий болсон юм чинь ийм томоохон шинэчлэлүүдийг хийх байх гэж ингэж харж байгаа юм. Энэ дээр нэг хариулт өгөөч.

3 дахь асуудал Тавинбэх даргаас энэ 6, 7 жил болж байгаа Багануурын дулааны цахилгаан станцын ажил маань үндсэндээ өнгөрсөн 4 жилийн хөтөлбөрт яваад нэг ч ажил хийгдээгүй. Одоо бүүр нэг үг өгүүлбэр ч байхгүй аваад хаячихсан байна ЗГ-ын хөтөлбөрөөс. Энэ ажил бүүр явахгүй гэж ойлгож байгаа юм болов уу? Яг зогссон гэж би ойлгохгүй байгаа, санхүүгийн маргаантай байгаа гэж ойлгож байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гантөмөр сайд Шадар сайд хариулах уу.

Л.Гантөмөр: Тийм. Тэгэхээр бид нар татварын шинэчлэлийн бодлогыг болбол хийнэ, нэмэгдүүлэх чиглэлийн бодлого бол байхгүй. Бууруулах чиглэлийн бодлогыг бол тууштай хийнэ. Хийхийн тулд бидэнд хугацаа хэрэгтэй байна. Тодорхой хугацаа зарцуулж, явал таны хэлдгээр татварынхаа баазыг нэмээд, авч байгаа дарамт, хувь хүн дээр очиж байгаа, албан байгууллага дээр очиж байгаа дарамтыг багасгах вэ гэдгийг их тодорхой тооцоолуудыг хийх юм байна лээ. Энэ дотор болбол их ойлгомжтой зүйл юу вэ гэхээр гэр бүлийн, гэр бүлтэй нь уясан татварын бодлогыг болбол шинээр гаргахаас өөр аргагүй байгаа юм.

Адилхан ажил хийж байдаг 2 хүн нэг нь 7 ам бүлтэй тэрийгээ авч явдаг, нөгөөдөх нь 3 ам бүлтэй тэрийгээ авч явдаг. Тэгсэн мөртөө орлогын албан татвар болбол адилхан төлөгдөөд явж байдаг. Тэгэхээр ард нь нөгөө амьдралд нь үлдэх үлдэц, тэр амьдралын хүртээмж. Бид болбол амьдралын чанарыг сайжруулахын төлөө байгаа учраас энэ дээр 1 дүгээрт бодлого хийнэ.

2 дугаарт хууль журам гэж яриад байгаа шиг татвар хураамж гэдэг 2 зүйл гараад ирчихсэн байгаа юм. Татвар нь их ойлгомжтой бага байгаад байдаг. Гэтэл хураамж нь ерөөсөө дийлдэхээ больчихсон. Тийм учраас энэ хураамжийг цэгцлэх ажлыг болбол ойрын үед хийх хэрэгтэй. Ямар хураамж, хэн авах вэ, яаж авах вэ, их тодорхой болгох ёстой. Давхар татвар, давхар хураамж гэдэг энэ журмаар гарч ирчхээд байгаа ард түмэн төлбөр төлдөг энэ хаалгануудыг болбол нэг нэгээр нь хаагаад явна. Ер нь бол татвар нэмэхгүй гэдэг дээр болбол ЗГ байр суурь нэгтэй байгаа. Татвараа буулга, буулгах ажлыг болбол маш ойлгомжтой судалгааны үр дүн дээр хийнэ.

Гаднын банк оруулж ирнэ, оруулж ирэх ёстой гэдгийг би түрүүн

танилцуулгадаа хэлсэн. Олон жил гадаадын хөрөнгө оруулалттай банк банкны салбар Монголд байгуулагдахгүй хаадаг. Таны хэлдгээр хийж чаддаггүй. 1 дүгээрт Монголын дотоодын энэ санхүүгийн орчин өөрөө эрсдэлтэй. Хамгийн том эрсдэл нь инфляц байгаад байгаа юм. Тэгэхээр бид болбол энэ тогтвортой өсөлт, инфляцын тогтвортой байдлыг маш чадамгайр мөнгөний бодлогоор зөв удирдаж чадах юм болбол энэ банкныг оруулж ирнэ.

Дээр нь хуулиар хаачихсан байгаа. Банкны хууль шинэчилсэн найруулга бэлэн болчихсон юм байна лээ. Тэр шинэчилсэн найруулгыг ойрын үед бид нар өргөн бариад, Банкныхаа хуулиар бид нар яг гаднын банк Монголд орж ирж үйл ажиллагаа явуулж болох тэр орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Ингэснээр болбол хүү буурах нь болбол ойлгомжтой. Эх үүсвэрийг бид нар Төв банкин дээрээ их хэмжээгээр татан төвлөрүүлж байгаа учраас л хүү өндөр байгаад байна шүү дээ. Тэгээд гадна, нөгөө талдаа болбол эх үүсвэр нь бага учраас хүү өндөр байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр болбол бид нар тууштай бодлого хийж, үнэхээр хүүгийн дарамт, өрийн дарамт 2-оос болбол бид нар ард түмнээ салгах нь бол эдийн засгийн өсөлтөөрөө салгах нь өөрөө бидний хамгийн тэргүүлэх зорилт байх болно гэдгийг хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр ААН-үүдийн татвар ер нь ямаруу байх юм гэдэг дээр нэг хариулсангүй шүү. Тэд нар дээр хүрч ирж байгаа татварын дарамт ямар байх юм бэ гэдгийг. Тавинбэх дарга 6 номер.

Н.Тавинбэх: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Багануур дүүрэгт 600мвт-ын хүчин чадалтай нүүрсний технологитой эх үүсвэр БНХАУ-ын төрийн компани концессоор барихаар гэрээ байгуулсан. Ингээд 10 дахь жилийнхээ нүүрийг үзэх гэж байна. 20 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ төслийг тусгасан, маргаантай байсан, эргэлзээтэй байсан,

бас концесс эзэмшигчээс тавьсан хүсэлтийг болбол бүрэн шийдсэн байгаа 20 онд, 20 онд бүүр. Тэрнээс хойш энэ төсөлд ямар ч ахиц гараагүй. Шалтгаанаа концесс эзэмшигч төрийн өмчийн компани учраас бизнесийн үндсэн чиглэл өөрчлөгдсөнтэй холбоотой энэ төслийг тэр тусмаа нүүрсний технологиор ажилладаг эх үүсвэрийг гадаад оронд барих төслийг бие даан хэрэгжүүлэх боломжгүй гэдэг ийм тайлбарыг өгдөг.

Ийм боломжгүй болсон учраас бид энэ концессын гэрээг гэрээний дагуу хүлээсэн үүргээ чадамжтай бусад компаниудаар гүйцэтгүүлэх эсвэл хамтарч гүйцэтгүүлэх, хамтрах ийм компанийг хайж байна, концесс эзэмшигчийг хайж байна гэдэг тайлбарыг өгдөг. Тэгээд одоо тэр ажил тодорхойгүйгээр 4 жил үргэлжилсэн, одоо ч тодорхой хариу өгөөгүй байгаа учраас бид чадлын дутагдалд энэ орсон үед бодитой хэрэгжих боломжтой бусад төслүүдийг тусгаж өгсөн байгаа гэдгийг хэлье. Гэхдээ энэ концессын гэрээ хүчин төгөлдөр байгаа. Хэрвээ концесс эзэмшигч талаас санаачилга гаргаад явбал ЗГ дэмжих, хамтарч ажиллах байр суурь хэвээрээ байгаа гэдгийг хэлье. Хэдийгээр ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй ч гэсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ хариулж байгаа хүмүүс жоохон тодорхой хариулна шүү. Яг цаашаагаа хийх юм уу, хийхгүй юм уу, энэ 4 жилдээ хэрэгжүүлэх юм уу, хэрэгжүүлэхгүй юм уу гэдгийг л асуух шиг боллоо шүү дээ. Танай Багануурын чинь хүн асууж байх шиг байна. Тавинбэх дарга. 4-өөс 4 жил ингээд л яваад байх юм уу хэдүүлээ. Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Наад 400мвт-ын эх үүсвэр чинь худлаа болж байх шиг байна. Тийм учраас 4 жил хууртагдаж ингэж явлаа. Тийм учраас одоо байгаа Багануурын дулааны станцыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг ярьж явахгүй бол тэр хийгдэх станц гэж

ярьсаар байгаад одоо байгаа станц чинь гал алдахад хүрээд байгаа юм. Тийм учраас би 1 дүгээр хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж, Багануурын одоо байгаа дулааны станцыг хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж, үйл ажиллагааны хөтөлбөрт оруулъя гэсэн ийм бодолтой байна. Эрчим хүчний яам бас дэмжиж өгөөрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн асуулт асууя. Батбаатар гишүүний микрофоныг нээе.

Б.Батбаатар: ЗГ 1 бүрэлдээд мөрийн хөтөлбөрөө оруулаад ирж байна. Энэ ЗГ яаж бүрэлдсэн юм бэ, гэрээ тэр 3 нам 118-ын бүлгийг бүрдүүлж байгаа 3 намын даргад нь бодвол гишүүддээ өгсөн байлгүй дээ. Бидэнд тэр гэрээ нь алга. ЗГ-ын яг бүрэлдүүлж байгаа энэ эрх зүйн үндэс нь юу байгаа юм бэ гэдэг зүйлийг мэдэж авмаар байна. Энэ Үндсэн хуулийн асуудал яригдана. Их Хурлын тухай хуулийн асуудал яригдана. ЗГ-ын тухай хуулийн асуудал яригдана. Сонгуулийн хуулийн асуудал яригдана. 1 ЗГ-т 3 нам нь орчихсон. Улсын Их Хурал энэ чигээрээ ингээд энэ асуудлуудыг шийдээд явбал Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан Үндсэн хууль зөрчсөн асуудлаар Цэцэд очих байх. Ер нь бол энэ асуудлыг сөхөж тавьж албан ёсоор хандана. Эрх зүйн үндсээ нэг хэлж өгөөд, дээрээс нь 3 намын дарга гарын үсэг зураад байсан тэр гэрээгээ нэг өгчихвөл зүгээр байна. Ямар гэрээн дээр үндэслэж энэ Засгийн бодлого цаашаагаа явж байгаа юм бэ? Тэр гэрээн дээрээ үндэслэж энэ мөрийн хөтөлбөр хийгдсэн байх.

Дараагийн асуудал нь Иргэний зориг ногоон намын мөрийн хөтөлбөрөөс хэдэн заалт орсон бэ? Тэр 20 хэдэн хуулийн төсөл байгаа. Тэр хуулийн төслүүдээс, яах вэ ямар хуулиудыг батлах вэ гэдэг дээр анхаарах ёстой. ЗГ санаачилж байгаа хуулийг нь бол бид нар давхар санаачлахгүй байж болох юм гэж үзэж байгаа юм.

3 дахь асуудал нь ЗГ энэ ашгийн төлөөх бизнес хийдгийг болимоор байна. ЗГ ашиг олдог 1 ширхэг ч бизнес хийх ёсгүй. Татвар, ашгийн татвараа аваад тэндээсээ үйл ажиллагаагаа зохион байгуулаад явах хэрэгтэй. ЗГ ашгийн төлөөх бизнес хийж байгаагаас шалтгаалж Монгол Улсын хэдэн 100 мянган хүн өнөөдөр гадаад улсад ажиллаж, амьдарч байна. Зээлийг нь, батлан даалтыг нь, газрыг нь, зөвшөөрлийг нь, хөрөнгө оруулалтыг нь оруулж өгөөд ашгийн төлөөх бизнес хийж байгаа тохиолдолд энэ ЗГ-тай иргэд чинь өрсөлдөж бизнес хийж амьдарч чадахгүй шүү дээ. Одоо хүртэл энэ ЭСЯ-дын гадаа Монголоосоо гарч ажиллах гэсэн хүмүүсийн очер дугаар урт цуваа байж л байна.

4 дүгээрт нь тэр шатахууны болон бусад нөөцүүдийг хангах талаар хуурамч буюу холимог шатахуун хэрэглэж байгаа тэр болгоны төлөөсийг нь иргэд машинаа эвдээд төлж байгаа шүү дээ. Энэ асуудлыг.../минут дуусах/

Ж.Бат-Эрдэнэ: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Батбаатар гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болбол энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан 6.8-д заасны дагуу энэ 5 жилийн үндсэн чиглэлдээ үндэслээд, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулдаг хуультай. Тэгэхээр ЗГ-ын энэ үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсаны дараа ЗГ-ын нөгөө энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батална. Тэгэхээр нөгөө гишүүдийн хэлээд байгаа зарим орхигдсон саналууд болбол тэр үйл ажиллагааны нэг жилийн төлөвлөгөөнд тусгагдаад явна.

Дээрээс нь Их Хурал болбол бас жилийн ажлын төлөвлөгөөг баталдаг гээд ингээд хуулийнхаа дагуу явж байгаа ийм бодлогын баримт бичгүүд. Иргэний

Зориг ногоон намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан заалтуудаас ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр саналаа ирүүлээч гэдэг би бас албан бичиг явуулсан. Тэгээд Батбаатар даргаас болбол Иргэний Зориг ногоон намын мөрийн хөтөлбөрийг над руу бол илгээсэн. Ингээд болбол ажлын хэсэг дээр яриад, Иргэний Зориг ногоон намын яг саналуудаас болбол энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт болбол тусгаад явсан. Жишээ нь Ногоон намын мөрийн хөтөлбөрийн 1.6-д заасан 17 хууль тогтоомж батлуулахаар заасан нэг ийм заалт байгаа. Жишээ нь энэ 17 хууль болбол бүхэлдээ хууль зүйн салбар, энэ төрийн өмчийн компанийн нээлттэй засаглал, төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хууль гээд хуулиудад өөрчлөлт оруулна гэсэн нэг ийм 17 хуулийн заалтууд байсан. Эдгээр заалтууд болбол ер нь агуулгынхаа хувьд бүрэн багтсан гэсэн үг.

Дээрээс нь нөгөө Үндэсний баялгийн сантай холбоотой, орон сууцжуулахтай холбоотой, ногоон шийдэл ногоон шилжилтийг дэмжих, жишээ нь ногоон орон сууц барьсан тохиолдолд дэмжих бүх талын дэмжлэг үзүүлэх гээд энэ агуулгуудыг болбол бас энэ үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. Тэгээд Батбаатар даргад хэлэхэд энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болбол өөрөө 3 намын хамтарсан ЗГ-ын тэр гэрээг суурилсан гэж хэлж байгаа болохоос биш хамтарсан ЗГ-ын гэрээ болбол Их Хурлаар оруулах бодлогын тийм баримт бичиг болбол огт биш. Тийм хууль зүйн үндэслэл ч байхгүй.

Тэгэхээр энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ 3 талыг илүү хариуцлагажуулж байгаа л гэж ойлгож болно. Энэ хамтарсан ЗГ-ын гэрээ бол. Энэ 15 жишээ нь мега төслүүдийг хамтарсан ЗГ-ын гэрээнд тусгасан. Энэ 15 төслийг хэрэгжүүлэхэд 3 нам хамтарна шүү гэдгээ илүү хариуцлагажуулж байгаа. Тэрнээс хамтарсан ЗГ-ын гэрээ болбол огт Их

Хурлаар хэлэлцэх шаардлага болбол байхгүй. Энэ бол 3 тал хоорондоо зөвшилцөөд, 3 намын дарга л ингээд гэрээгээ зурсан гэсэн үг. Тэгэхээр үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжихэд илүү сайн арга хөшүүрэг болж өгч байгаа л гэж ойлгож болно.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Нөгөө Учрал сайд үргэлжлүүлээд нөгөө ЗГ ашигийн төлөөх бизнес эрхлэхгүй байх чиглэл рүү орсон юм уу, ороогүй юм уу энэ бол их чухал асуудал. Иргэд маань ажилтай орлоготой байхад их чухал асуудал.

3 намын хоорондын гэрээг яах вэ өгөхгүй гэвэл авахгүй байж болно. Уг нь бол аваад үзчихвэл нэг их тийм нууцын айхтар нуугаад байх шаардлагатай зүйл биш байх л гэж найдаад байгаа юм. Тэрийг Их Хурлаар хэлэлцэхгүй гэдгийг бол мэдэж байгаа, мэднэ. Тийм болохоор энэ гэрээн дээрээ юу заачихсан юм бэ гэдгийг нь олоод харчихвал бас Засаг ажиллахад учиртай юм болов уу гэж ойлгоод байгаа юм. Их Хурал өөрөө Ерөнхий сайдыг томилж, Ерөнхий сайд нь ЗГ-ын бүрэлдэхүүнээ томилж байгаа. Цаашидаа бол энэ чинь Үндсэн хуулиараа нэг бүлэг болох ёстой шүү дээ 3 нам чинь. Тэрийг яах гэж байгаа юм бэ?

Ж.Бат-Эрдэнэ: Гантөмөр, Учрал сайд.

Н.Учрал: Энэ удаагийн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болбол ийм 4 тэргүүлэх чиглэлтэй. Үүн дээр эдийн засгийн бодлого гэдэг гол чиглэл байгаа. Үүн дээр эдийн засгийн эрх, эрх чөлөө, дээрээс нь энэ төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх гэдэг энэ үндсэн зарчмыг барьсан. Тэгэхээр энэ 3 намын мөрийн хөтөлбөрөөс жишээ нь АН-ын Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн энэ эдийн засгийн эрх чөлөө, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, хувийн эрх зүйн шинэчлэл гэдэг заалтуудыг илүү удирдлага болгосон. Тэгэхээр эдийн

засгийн бодлого гэдэг чиглэл бол бүхэлдээ төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу төр өөрт байгаа өмчөөсөө сална гэдэг ийм л үндсэн зорилгыг агуулж байгаа юм.

Тийм учраас энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу ч гэсэн энэ төрийн өмчит компаниудын засаглалын асуудлыг болбол бид нар цогцоор нь авч хэрэгжүүлнэ. Тэгэхээр үүн дээр.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь болбол Улсын Их Хурлаас Засгийн газраа байгуулуулж байгаа шүү дээ. Тэгээд хөтөлбөрөө өнөөдөр хэрэгжүүлж байгаа юу, танилцаж бид нар батлах гэж байна. Тэгэхээр энэ үндэслэл дээр байгаа тэр гэрээг уг нь болбол бас нэг Улсын Их Хурлын гишүүдэд нэг танилцуулаад, ийм ийм үндэслэлтэй, ийм ийм гэрээ, ийм ийм зүйлүүд 4 жилийн хугацаанд хийхээр тохирлоо. Тэгээд тэрийгээ дагаад өнөөдөр ийм ийм хөтөлбөр орж ирж байна гээд ер нь танилцуулгыг нь хийсэн нь зүгээр байх. Түүнээс биш бид нар адилхан л хэвлэлийн мэдээлэлтэй л байгаад байгаа шүү дээ. Гантөмөр Ерөнхий сайд, Шадар сайд.

Л.Гантөмөр: Тийм. Ер нь би түрүүн нэг улсын энэ төрийн өмчтэй компаниудын тухай хэлсэн үгэн дээр Батбаатар яагаад байх шиг байна. Реакцилаад байх шиг байна. Ер нь бол ашиггүй баахан компани тэжээж явдаг байхгүй юу төр өөрийн өмчтэй гээд. Тэр компаниудыг бол татан буулгах хэрэгтэй л гэж байгаа юм. Миний хэлж байгаа санаа бол. Ашигтай байгаа жишээлбэл Эрдэнэс тавантолгой ч гэдэг юм уу, Эрдэнэт гээд энэ үйлдвэрүүдийг бид нар яаран хувьчлах барих ажил руу орж болохгүй шүү дээ. Тэгээд бид нарын ажил, бид нарын гол тавих шаардлага юу вэ гэхээр энэ томоохон улсын үйлдвэрийн газрууд нь нээлттэй болох хэрэгтэй. Олон түмний хяналттай болох ёстой.

Нөгөө талдаа ашиггүй баахан тэжээгдээд явж байгаа цаасан дээр байгаа компаниуд байгаа. Цаасны компани. Төсөл хэрэгжүүлэх нэртэй, тэр компаниудыг болбол бид нар татан буулгах ёстой гэсэн ийм зарчимтай байгаа. Жишээлбэл Эрдэнэс тавантолгой гээд нэг компани биш ээ, Тавантолгой төмөр зам гээд компани байна, Монголын төмөр зам гээд компани байна, давхардсан бүтэц байна энийг яах вэ гэдэг юм яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр бол ашиггүй ТӨК-ийн нэрээр цалин авдаг, мөнгө үрдэг асуудлыг бол байхгүй болгоё гэсэн ийм зүйл байгаа шүү.

Хамтарсан ЗГ-ын гэрээ бол тийм хүнээс нууц зүйл бол байхгүй. Үндсэндээ болбол бид нар яагаад хамтарч байгаагаа тодорхой болгож байгаа. Нөгөө талдаа юу хийхийгээ тодорхой болгож байгаа. Ил тод, энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээр туссан 4 том зорилтыг л ажил хэрэг болгоё гэж байгаа юм. Тэрийгээ товчлоод л тавьчихсан байгаа. Нөгөө талдаа намуудын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Эдийн засгаа урагшлуулах томоохон төслийг хөдөлгөнө гэсэн ийм л зүйл, заалт байгаа. Удахгүй тэгээд та бүхний гар дээр хүрээд ирэх байх. Тэр бол тийм нууц зүйл бол биш.

1 дүгээрт бүсчилсэн хөгжлийг хийе, 2 дугаарт хүний хөгжлийнхөө бодлогыг хүчтэй явуулъя, 3 дугаарт эдийн засгийн бодлого байна, энэ нь эдийн засгийн эрх чөлөөг хангах чиглэлээр хийнэ гэж байгаа юм. 4 дүгээрт болбол засаглалын асуудал. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогыг явуулна гэсэн ийм 4 зорилтын хүрээнд энэ үйл ажиллагааны хөтөлбөр өөрөө боловсруулагдаж орж ирж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Зам, тээврийн төрийн нарийн байна уу Батболд? Сая тэр шатахуунтай холбоотой асуулт асуусан уу? Шатахууны нөөцтэй холбоотой асуудал. Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: ЗГ-ын ирэх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр орж ирсэн байна. Тэгээд 1 эхний бас нэг үзэл баримтлалын шинжтэй зарим нэг зүйлүүдийг асуухаас өөр аргагүй ийм нөхцөл байдал бас байна. Үзэл баримтлалынх нь түвшинд ер нь ингээд харахаар 149 томоохон төслийг хэрэгжүүлнэ. Энэ 149 томоохон төсөл нь нь 120 их наяд төгрөг байна гээд ингээд дүнгүүд байна л даа. Би бас яг Ерөнхий сайдыг томилогдож байхад бас тухайн үед асууж байсан. Одоо тэгээд энэний дараа баахан мега төсөл гээд зүйл, төрөөс хийх мега төсөл гэдэг зүйл орж ирэх үү гэж тухайн үед би бас асууж байсан. Тэгэхээр яг л тийм байдалтай л төсөл ингээд орж ирж байна.

Тэгэхээр энд хамгийн гол нь бид нар төр ийм их ачаа бүгдийг нь хийнэ. Зөвхөн зураг төсөл нь бараг хагас их наяд болчихсон, нийт дүн нь 120 их наяд. Өнөөдөр бид нар 70 их наядын л ДНБ-тэй улс шүү дээ. Тэгээд 4 жилд 120 их наядын төсөл хэрэгжүүлнэ гэхчхэн ийм нэг бид нарын яриад байдаг нөгөө нэг том төр, төр том байхаар авлигаждаг гэдэг энэ зүйл рүүгээ хэтэрхий их алхчихсан ийм үзэл баримтлал чинь энэний цаана байгаад байгаа юм биш үү. Энийг харин хэрхэн яаж тэр хувийн хэвилийн оролцоо, Монгол улсын зээлжих зэрэглэл сайжирч, бизнесийн орчин сайжирч, бусдаар яаж хийлгэдэг болох тухай, тэр гадна, дотнын хөрөнгө оруулагчдыг татах тухай тэр үзэл санаа тодорхой харагдахгүй нэг их гоё гоё төслийн нэртэй, гоё гоё ийм л зүйл л болчихоод байна л даа.

Тэгээд орлого талаа харахаар яг өнөөдөр бодит байдал дээр төсөвт тонн нүүрсийг 140 доллароор төсөвт тавьчихсан байгаа. Өнөөдөр бодит байдал дээр зах зээл дээр 120 болоод буучихсан. Зэсийн үнэ чинь тэрнээс буучихсан. Таамаглал нь зэсийг бараг 7 мянга руу орно гэсэн таамаглал байгаа юм байна лээ. Тэр орлого хаана байгаа

юм бэ? Тэгээд баахан ДНБ-ээсээ том дүнтэй 120 их наяд гээд том дүн тавьчихсан. Тэгэхээр энэ бүгдийн чинь цаана бид нарын бас нэг тэр үзэл баримтлал, хувийн хэвилийн оролцоо, төртэй холбоотой авлигыг бууруулна гэдэг энэ зүйлсээсээ ингээд гажсаад нөгөө тийшээ явчхаад байгаа юм биш үү дээ. Тэгэхээр би энэ хэсэг дээр л нэг тодруулга өгөөч гэж дотрыг нь задлаад хараад яривал зөндөө л юм гарах л байх л даа. Зүгээр энэ хэдэн том тоог нь харахад л ийм л зүйл харагдаад байна л даа.

Ж.Бат-Эрдэнэ: Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Яах вэ нийт авч хэрэгжүүлэх арга хэмжээ гээд харахаараа 140 хэд гэдэг тоо гарч байгаа юм. Яг тэргүүлэх чиглэлд хэрэгжүүлэх ажил болбол 14 төсөл гээд өчигдөр би танилцуулсан. Бүлгийн хурал дээр. Тэрнээс толгой 10 төслийг нь бас танилцуулсан. Тэгээд энэ болбол цэвэр 100 хувь Засгийн мөнгөөр төсвөөр хийе гэж байгаа ажил бол энд байхгүй байгаад байгаа юм л даа. Жишээлбэл Гашиун сухайтыг, Гашиун сухайт-Ганц модыг холбосон төмөр замын ажил бол хамгийн 1 дүгээрт тавигдаж байгаа. Энэ ажил хийгдэх юм бол бид нар 20 сая тонн нүүрсийг нэмж экспортлох хүчин чадал бий болгоно гээд. Энэ дээр зарцуулах мөнгө болбол жишээлбэл манай төсвөөс бол байхгүй байхгүй юу гэх мэтчилэн энэ төслүүд өөрөө манай эдийн засгийг л дэмжих, эдийн засгийн хөгжлийг бий болгох, хувийн хэвчлээр хийлгэх ажлууд асар их байгаа юм.

Тэгээд та бүхэн та өнгөрсөн парламентад сууж байхдаа Төр, хувийн хэвилийн тухай хуулиа баталчихсан. Тэр хуулийн хэрэгжилтийг жоохон наашаа татаад, тэр хүрээндээ бид нар ер нь энэ төр өөрөө хийе гээд зүтгээд байгаа юмаа хувийн хэвчлээрээ хийлгэвэл яасан юм бэ гэдэг хандлага дээр гарч ирж байгаа төслүүд шүү. Энийгээ танд тусгайлан бас нэг цаг гаргаж тайлбарлах ёстой байх гэж би бодож байна. Өчигдөр нөгөө хөдөө орон нутагт та ажилтай байсан

учраас. Тэгэхээр ерөнхий мэдээллээ болбол ингээд нэг талыг бариад, бид нар орлогогүй байж баахан зардал тавиад л улс орноо дампууруулах ч юм уу эсвэл ийм гоомой юм хийхгүй шүү дээ. Хамтарна гэдэг болбол харилцан хяналттай байгааг л хэлж байгаа юм. Бодитой ажил хэрэг болгох, ажил хэрэг болгох зорилтын төлөө л яваа.

Тэгээд энэ АН, МАН, АН, ХҮН намын мөрийн хөтөлбөр дээрээс босож ирж байгаа. Энэ бол агаараас ерөөсөө босож ирээгүй. Нэг үгээр хэлбэл хариуцлагатайгаар сонгуульд бид амлачихсан амлалтаа одоо ажил хэрэг болгох ёстой. Тэгээд таны хэлдгээр хувийн хэвилийн орон зайгаа тэлж байж явах юм биш үү гэдэг философи бол яг энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн гол тулгуур зарчим болсон байгаа шүү. Тан дээр орчуулж тайлбарлаж байгаа хүмүүс жоохон буруу тайлбарлаад байх шиг байна. Буруу орчуулаад байх шиг байна. Энэний зөв орчуулгыг болбол яг бодитойгоор манай гишүүд яг энийг боловсруулж байгаа хүмүүсээс нь үзэж харах, сонсох хэрэгтэй.

Тэгээд яг Цогтгэрэл гишүүнд болбол бид нар бүүр яг анхны draft-ийг өгсөн байгаа. ХҮН намын ямар хөтөлбөр орсон юм, АН-ын ямар хөтөлбөр орсон юм(МАН-ын ямар мөрийн хөтөлбөрийн заалтууд орсон бэ гэдгийг их тодорхой өгчихсөн. Тэрийг ингээд шүүгээд харах юм болбол ер нь, ер нь л Монголынхоо асуудлыг шийдэх гэж оролдож байгаа юм байна даа гэдгийг уг нь бүгдээрээ ойлгох байх гэж би үндсэндээ бодож байна. Тийм учраас аль нэг намын, аль нэг үзэл суртлын тийм хөтөлбөр бол биш. Бид бол ард түмний дэмжсэн саналуудыг ажил хэрэг болгоно. 2 дахь нь үнэхээр тулгамдсан асуудлыг шийднэ. Одоо бид нар ухарч юм хараад хэрэггүй. Урагшаа хараад асуудлаа шийдэхийн төлөө.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах юм уу? Гэрт нь очиж тодруулъя гэсэн үү үгүй юу? Ер нь болбол яах вэ ийм зүйлээ

Гантөмөр сайдаа яг эвтэйхэн шиг, аятайхан шиг энэ хүмүүст тайлбарыг нь өгөхгүй болбол ингээд хэг ёг гэсэн байдлаар бол наадах чинь тайлбар биш байлаа шүү. Энэ их наяд төгрөгийг бид нар хаанаас босгох юм бэ, ААН-үүдээс босгох юм уу, хаанаас босгох юм бэ, гаднаас босгох юм уу, төсвөөс босгох юм уу энийгээ бид нар тодорхой болгохгүй болбол 2 жилийн дараа та бүхэн бүтэхгүй юм байна, бүтэхгүй юм байна, мөнгө төгрөгийг нь ч өгөхгүй юм байна, гаргадаггүй юм байна гээд ингээд Засгийн газраа хаяад явдаг түүхтэй шүү. Түүх байгаа шүү энэ. Тэр давтагдах вий гэдэг утгаар би бас тодруулчихъя гэж бодож байгаа юм. Энэ мөнгө хаанаас гарч байгаа вэ, хаанаас гарах юм бэ, яаж санхүүжилтээ хийх юм гэдэг асуудлыг дараа нь та бас нэг тодруулчихаарай. Бямбацогт сайд. Яах вэ Байнгын хороон дээр тэгээд нэрсээ өгсөн юм, асуух асуултаа асуучих. Дарамтлаад татуулчихаж байгаа юм уу?

Гишүүд асуулт асууж дууслаа. Санал хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд байвал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.8.8-д гишүүд хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлнэ гэж заасан байгаа. Дэмжсэн, дэмжээгүй санал хэлэх гишүүд байна уу? Шижир. Шижир гишүүнээр тасаллаа. Шижир гишүүний микрофон өгье.

Ө.Шижир: Би түрүүн үг хэлэх дээр уг нь дарсан юм. Гэхдээ одоо хэлчихье дээ. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар нөгөө чуулганы танхимд хэлэлцүүлэг явах, асуулт асуух, үг хэлэх нь нөгөө нэг хязгаарлачихсан. Тэгэхээр Байнгын хороо тийм ажил хэрэгч байдалтай байхгүй бол нэг бол тийм улс төржссөн асуулт өгөөд, хариулт хариулаад, үгүй бол хариулт тавих хүн байхгүй, тэнд 20 гаруй ирээд суучихсан,

ингээд 3 асуулт асуусан нэгд нь бүтэн, нэгд нь тал, нөгөөдөх нь огт хариулт авсангүй л дээ. Тэгээд Байнгын хорооны хурал өөрөө ийм ажил хэрэгч байдалтай болохгүй бол бид нар нөгөө чуулган дээр юмнууд чинь багасчихсан шүү дээ. Тэгээд одоо жишээ нь түрүүн бас тодруулах гэсэн миний тодруулгын минутыг өгсөнгүй.

Бид нар хангайн бүсийг, төвийн бүсийг хөдөө аж ахуйн төрөлжсөн тэргүүлэх чиглэлтэй болгоно гэсэн мөртөө яг малаас гаралтай түүхий эдийг хэрхэн яаж боловсруулсныг маш тодорхой нэг ч үг, үсэг, өгүүлбэр алга энэ мөрийн хөтөлбөрт. Манай намын мөрийн хөтөлбөрөөс яаж суусан юм бэ? Би бүлэг дээрээ асуугаад бас хариулт авч чадаагүй.

Хэвлэлийн эрх чөлөө гээд ганцхан бүлэг заалттай. Манайх хэвлэлийн эрх чөлөө тэгж их хангагдчихсан супер лаг улс бол биш л байх тийм ээ? Тэгээд энэ мөрийн хөтөлбөрт ганцхан тийм заалт байна. Төр хувийн хэвилийн хамтын ажиллагаа гээд гуравхан заалт байна. Гэтэл ингээд зөвхөн улсын төсвөөр улс хөгждөггүй шүү дээ. Тэрийг та нар бүгд бүгдээрээ мэдэж байгаа. Явж, явж нийт энэ эдийн засгийн бүх эргэлт чинь хувийн хэвилийн нуруун дээр л байгаа. Тэгтэл хувь болон хувийн хэвшил болон төрийн байгууллагууд хэрхэн хамтрах тухай гуравхан өгүүлбэр л байна. Хувийн хэвилийн хэрэгжүүлж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүдийг бид нар энд тусгах ёстой. Нэг бол ерөнхий утгаар нь оруулах ёстой. Тэгэхгүй бол дандаа нэг төрөөс хийх гэж байгаа ажил хөтөлбөр шиг ийм юм хийчихсэн.

Тэгээд энэ өмнөтгөл дээр энэ танилцуулсан өмнөтгөл дээр жишээ нь эдийн засаг 5,6 хувиар өсөх ёстой байсан ч зудын улмаас 8,1 сая толгой мал хорогдоод, хөдөө аж ахуйн салбарт агишилт үүссэн гээд биччихсэн байгаа мөртөө мал болон малчдаас гаралтай түүхий эдийг хэрхэн яаж боловсруулах, тэр үйлдвэрүүдийг яаж ашиглалтад

оруулах тухай нэг ч үг, үсэг өгүүлбэр алга. Нөгөө Эмээлтийн цогцолбор яасан юм бэ, Дарханы арьс ширний цогцолбор яасан юм бэ? Яг үндсэндээ бид нар 98 он, яг үндсэндээ бид нар Эрдэнэтээс хойш нэг ч аж үйлдвэр хийж үзээгүй улс шүү дээ манай улс чинь. Тэгээд ийм их бодлогын яам ийм их бодлогын баримт бичиг хийгээд байдаг бид нар үүн дээрээ яаж ажиллах юм бэ гээд.

Тэгээд асуултдаа бас тодорхой дараа дараагийн Байнгын хороон дээр асуултдаа тийм тодорхой хариултууд авдаг баймаар байна. Энэ дээр ингээд малын гаралтай түүхий эд гээд ингээд биччихсэн. Одоо бид нар энэ вакцинтай холбоотой асуудлыг миний мэдэхийн 2008 оноос хойш л ярьсан. Унгарын зээл ярьсан, Био комбинат ярьсан, одоо бол шийдэгдээгүй ингээд л ерөнхий байдлаар л оруулаад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм юмнуудаа цаашидаа ингээд анхаараад, асуултад хариулах хүмүүс бас тодорхой хариулттай байхгүй бол, бид нар дахиад нэг ийм 598 дахь ийм лоозогносон баримт бичиг үйлдэх гээд байна шүү. Эргээд дүгнэсэн дүгнэлтийг нь яаж гаргах юм бас тодорхойгүй. Тэгээд нэг ийм зузаан зузаан боодол цаастай үлддэг. Эргээд дахиад бид нар 2010, 1996 онд хөгжлийн баримт бичиг боловсруулж байхдаа 2030 он гэхэд 17500 доллар хүргээд технологиор тэргүүлсэн улс болно гээд бид.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дэгийн чуулганы дэгийн тухай хуулийн 9.17 Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт, гүйцэтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд болон энэ хууль хэлэлцэх дэгийг тусгайлан зохицуулсан бусад асуудлыг хэлэлцэх үед гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй гэж байгаа шүү. Чуулган дээр тийм. Энэ асуудлууд саяын хэлсэн асуудлууд дээр шүү.

Нөгөөтээгүүр сая Шижир гишүүний хэлсэн үгтэй санал нэг байгаа шүү. Би түрүүнээс хойш хэлээд байгаа Гантөмөр сайдаа саяын тэр хариулж байгаа хариулт эд нар чинь тэр нар бүлэг дээрээ ярьж байгаа асуудал биш шүү. Энэ болбол Байнгын хорооны хуралдаан шүү. Тийм болохоор хувьчлан очиж, бараг л ч гэрт нь очиж хариултыг чинь өгчихье эд нар гээд байх юм байхгүй. Энийг чинь зөвхөн Байнгын хороо гэхээсээ гадна ер нь болбол том асуудлаа бид нар хэлэлцээд, асуудлыг шийдээд ингээд явж байх ёстой шүү. Тэр утгаараа бол бүрэн дүүрэн хариулж байх хэрэгтэй. Тэр сая ажлын хэсгийнхэн болбол дандаа дутуу дутуу хариуллаа шүү дээ. Тэгээд би нэг хурал даргалж байгаа гээд эндээс юмнуудыг нь асуултыг нь тодруулаад байх бас шаардлага байхгүй шүү дээ. Асуусан асуултад нь бүрэн дүүрэн хариулж байгаад, бичиж ав л даа. Цээжээрээ л тийм том, том толгойтой юм уу, цээжээрээ л шууд, шууд хариулаад л, тал дутуу хариулаад явж байгаа.

Гишүүд, сая Шижир болбол сая тодруулах уу гэхэд тодруулаагүй шүү дээ. Тодруулаад, тодруулаад авчхаарай. Үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Санал хураалтыг эхлээд юу яах уу туршилтын санал хураалт нэг явуулаадах уу? Санал хураалт. Туршилтын санал хураалт явуулъя, санал хураалт. Болж байна уу бүгдээрээ? Болж байх шиг байна.

Санал хураалт. Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хэд вэ? 20-оос 14 гишүүн буюу 80 хувийн, 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт

шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж болно гэж заасны дагуу Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулна. Тэгээд ажлын хэсэгт орох гишүүд саналаа өгнө биз. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Шижир танилцуулъя. Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

14.36 цаг

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудал

2 дугаар асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1-д, 87.1-д Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Цэцийн тогтоолоор хууль, тогтоолын зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгосон бол Улсын Их Хурал хууль, тогтоолд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэнэ гэж байгаа юм.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн зарим заалт, 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж, Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 78 дугаар тогтоолыг баталсан.

Дээрх маргааныг Үндсэн хуулийн цэц дахин хянан шийдвэрлэж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолыг гаргасан байна. 2023 оны 5 дугаар сарын 31-ний Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт, мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 44 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан ба Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар батлагдсан Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. Хууль тогтоох үйл ажиллагаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулахад чиглэсэн тул Байнгын хороо Цэцийн тогтоолтой

холбогдуулан хууль тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зохих заалтыг та бүхэнд уншиж танилцуулъя. 15 дугаар зүйл. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ. Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийг шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар дахин шийдвэрлэж болно гэсэн ийм заалт байна шүү. Ийм болохоор Цэцэд өөрсдөд нь болбол бүрэн эрх нь байгаа юм байна. Ингээд тогтоолоо өөрчлөлт оруулахгүйгээр ингээд явах нь байна.

Цэцэд өөрсдөд нь эрх нь байгаа юм байна тийм үү. Асуулт, шууд юу яах юм уу. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр тогтоолтой холбогдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

14.40 цаг

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлыг хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

